

Цэг, толбо, зураасыг шүншиглэн амилуулагчид

С.Батцоож

МУБИС, Дүрслэх урлаг технологийн сургууль, Дүрслэх урлагийн тэнхим

Хураангуй

XX зууны эхэн үе хүртэл бурхны судар, номыг модон барын аргаар дардаг байсан бол улмаар XX зууны дөчөөд оноос монголд өрнөдийн уран зургийн арга нэвтэрч эхлэхэд нийгэм цаг үеэ даган судар, номын чимэглэлд төдийгүй зурагт хуудас, ухуулах хуудас, нийгмийн сэдэвт захиалгат бүтээлүүд зэргийг хийх хэрэгцээ өсөн нэмэгдэж зураасан зургийн чиглэл болох барын урлаг оргилдоо хүрч дан ганц модон бар бус төмөр бар чулуун бар, хулдаасан барын урлаг болж дэлгэрсэн байна. Тэр л үеэс нийгмийн өөрчлөлт шинэчлэлт, бүтээн байгуулалтыг дагаад ард түмнийг уриалан дуудах ухуулах хуудас, байгалийн болон сэдэвт зураасан зураг бүхий “плакат”-ын зургууд бүтээгдэх болсон юм. Улмаар монгол модон бар зургийн хэрэглээ мартагдаж чулуун бар, өнгөт бар, төмөр барын урлаг төдийлөн дэлгэрээгүй байсан учир хулдаасан дээр ухааж хэвлэн буулгадаг “хулдаасан бар” зураг нь илүү цар хүрээтэй өргөн дэлгэрч олон арван бүтээлүүд хийгдэж ард түмэнд танигдаж эхэлсэн байдаг. Энэ л үед буюу 1960-1980 аад онд МУБИС-ийн Дүрслэх урлаг технологийн сургуулийн Дүрслэх урлагийн тэнхимийн уран бүтээлч багш нар Монголын дүрслэх урлагийн хүрээнд Зураасан зургийн төрөл, түүн дотроос хулдаасан бар зургаараа онцгойрч, нэрд гарч байсан юм.

Түлхүүр үг

Зураасан зураг, бар зураг, хулдаасан бар, цэг, толбо

Удиртгал

Дорно дахинд манай эриний VI зуунаас, Өрнө дахинд сэргэн мандалтын эхэн үед бий болж хөгжсөн барлах урлаг нь Хятадаас Япон, Солонгос, Энэтхэг, Түвд, Монгол зэрэг орнуудад бурхны шашинг даган нэвтэрч улмаар олон зуун жилийг туулан хөгжихдөө зураасан зургийн биеэ даасан томоохон төрөл болж дэлгэрсэн байдаг. Барлах урлаг нь Монголын дүрслэх урлагийн хөгжилд онцгой байр суурийг эзэлдэг бөгөөд манай ард түмний амьдралын хэв шинж, ёс заншил, уран сайхны сэтгэлгээний онцлог, нийгмийн цаг үеийн үйл явдал, өөрчлөлт, шинэчлэлтийг илэрхийлэхэд голлох үүрийг гүйцэтгэсээр ирсэн юм.

XX зууны эхэн үе хүртэл хийд дуганы “бархан”-д бурхны судар, номыг модон барын аргаар барлан хэвлэдэг байсан бол улмаар нийгэм цаг үеийн хөгжлийг даган судар, номын чимэглэл, ухуулах хуудас зэргийг барлах хэрэгцээ өсөн нэмэгдэж улмаар барын урлаг нь модон бар, төмөр бар чулуун бар, хулдаасан бар хэмээн дэлгэрэн хөгжсөн. Ц.Эрдэнэцог “XX зууны дөчөөд оноос монголд өрнөдийн уран зургийн арга нэвтэрч эхлэхэд зураасан зургийн чиглэл зурагт хуудас, усан будгийн зураг, бар зургийн шинэ төрлүүдээр өргөжин хөгжжээ”(Дүрслэх

урлагийн тэнхим, 2009, х.77) хэмээсэн байна. Учир нь тэр үеэс нийгмийн өөрчлөлт шинэчлэлт, бүтээн байгуулалтыг дагаад ард түмнийг уриалдан дуудсан ухуулах хуудас, байгалийн болон сэдэвт зураасан зураг бүхий “плакат”(ухуулан сурталчлах зураг)-ын зургууд бүтээгдэх болжээ.

Зураг 1

Д.Амгалан “Сургуульдаа” 1971 он. Хулдаасан бар 33x60



Эх сурвалж: МУЗГалерейн цомог. 2007 он

Нэгэн үед монгол модон бар зургийн арга ажиллагаа мартагдаж чулуун бар, өнгөт бар, төмөр

* ✉ s.battsooj@gmail.com

барын урлаг төдийлөн дэлгэрээгүй байсан учир хулдаасан дээр ухаж хэвлэн буулгадаг “хулдаасан бар” зураг нь илүү цар хүрээтэй хөгжиж эхэлжээ.

Энэ талаар судлаач Б.Бадрах “1960-аад оны эхнээс зураасан зураачдын дунд хулдаасан барын урлаг амжилттай хөгжиж олон чадварлаг бүтээлүүд гарсан юм. Хулдаасан бар, суурь бар зурагт хүчтэй хөгжсөн нь номын зураг чимэглэлийн урлагт нөлөөлж, номын зураг чимэглэлийг хулдаасан бараар бүтээх болов”(2000, х-92) хэмээн тодотгон хэлсэн байдаг.

Зураг 2

Д.Амгалан “Уургач” 1971 он. Хулдаасан бар 32х33



Эх сурвалж: МУЗ Галерейн цомог. 2007 он

1960-аад оны дунд үеэс зураач Д.Амгалангийн “Сургуульдаа” 1971 (Зураг-1), “Дөрөөнд”, “Уургач” 1971 (Зураг-2), “Сайн байна уу ээжээ” 1972 (Зураг-3) зэрэг ард түмний сайн мэдэх цуврал зургууд, мөн зураачдын “Саналбат” хамтлаг /Д.Сандагдорж, Б.Нацагдорж, н.Батсүх/ хэсэг зураачидтай хамтран нийгмийн цаг үе, бүтээн байгуулалтыг харуулсан хулдаасан бар зургийн бүтээлүүд тодорч байв. (Энхтунгалаг. 2008, х-93)

Судалгааны хэсэг

Эдгээр уран бүтээлчдийн хамт нэгэн жарны түүхтэй МУБИС-ийн Дүрслэх урлаг технологийн сургуулийн Дүрслэх урлагийн тэнхим (Хуучнаар УБДС-ийн зураг шугам зургийн тэнхим)-ийн уран бүтээлч багш нар 1960-1980 аад онд зураасан зургаар монголын дүрслэх урлагийн хүрээнд тодорч байсан юм. Өөр өөр хэлбэл зураасан зургийн төрөл дотроос хулдаасан бар зургаараа онцгойрч байсан үе гэж хэлж болно.

Зураг 3

Д.Амгалан “Ээжээ сайн байна уу” 1972 он. Хулдаасан бар 30х33



Эх сурвалж: МУЗ Галерейн фонд

Нэрт зураач, багш С.Нацагдоржийн иргэний болон уягийн сэдэвт “Адуучин” (1962), “Лимбэчин” (1962) “Эх нутгийн салхи” зэрэг хулдаасан бар зураг нь тэр үеийн оргил бүтээлүүдийн тоонд зүй ёсоор ордог юм.

Зураг 4

С.Нацагдорж “Адуучин” 1962 он. Хулдаасан бар 35х70



Эх сурвалж: МУЗ Галерейн цомог. 2007 он. X-50

Зураач С.Нацагдоржийн 1962 онд бүтээсэн “Адуун сүрэг” (Зураг-4) бүтээл нь өглөөний наран мандах их тал нутагт салхи сөргүүлэн адуугаа хураан эмээл дээрээ босон давхих адуучин залуугийн ид хав, эзнийхээ исгэрээнд омогшин давхих адуун сүргийн төвөргөөнөөр хөдөө нутгийн амгалан тайван өглөөг сэрээх малчин амьдралын сайхан эрч хүчийг харуулсан байдаг.

Тус бүтээлээр хөдөө нутгийн залуу малчдыг магтан дуулж, тэдгээрийг тал нутагт урин дуудах их утга санааг агуулж байсан нийгмийн захиалгат бүтээл гэж нэг хэсэг нь үздэг бол зарим судлаачид адуун сүргийн сүр хүч, адуучин залуугийн ид хавыг харуулсан аж байдлын сэдэвт бүтээл

гэж үзэх нэг нь ч бас байдаг. Тиймдээ ч судлаач Л.Батчулуун “тус бүтээлийн гол дүр нь жирийн адуучны дүрслэлээр зогсохгүй тарлан цастай хаврын тал нутгийг морин туурайгаар бөмбөрдөн нойрноос сэрээсэн шинэ үйл явдлын илэрхийлэл байх магадтай” (2008, х-85) хэмээн бичсэн байдаг. Ямартай ч адуун сүргийн тоог нэмсэн нялх унаганы тэрвийх дүр үзэгдэж, эхийнхээ араас зөөлхөн янцгаах чимээ сонсогдох шиг болж орчлон сэрж, монголын хөдөө талын үзэсгэлэн гоог бүрдүүлжээ.

Юутай ч тус бүтээл нь зохиомжийн хувьд тэнгэр газрын заагаар харааны түвшинг авч хошуулдсан алслалтаар бүх дүрслэлээ нэгтгэн улмаар өглөөний мандаж байгаа нарны ташуу тусгалд, адуун сүргийн толгой, нуруу, сүүл, хөл зэрэг нь гэрлийн эсрэг хүрээлэгдэн харагдаж, олон адууны сүүдэр, газрын бараан хэсгүүдтэй уусан сүлэлдэж хайрга чулууны гялталзсан гялбаан дунд ганц унага цойлон байгааг биеийн бараан сүүдэр болоод нуруу, дэл сүүлэн дээр тусах гэрлээр ялгаруулан дүрсэлсэн нь хар цагаан өнгөөр ямар гайхамшигтай тоглож, бас дүрсэлж чаддаг уран бүтээлч болохыг нь харуулж байна.

Зураач 1962 онд бүтээсэн “Лимбэчин” (Зураг-5) бүтээлдээ бөөн цагаан үүлсийн наана алслагдан цувран одох өндөр хүчдэлийн шугамын дор лимбэ үлээж буй залуу хүүг дүрсэлсэн байдаг.

Зураг 5

С.Нацагдорж “Лимбэчин” 1962 он. Хулдаасан бар 46х70



Эх сурвалж: МУЗ Галерейн цомог. 2007 он. Х-39

Тус бүтээлийг сайтар ажвал алслагдан буй өндөр хүчдэлийн шугамаар уужим тал нутгийг илэрхийлж, түүний наахна өдөржин хонь дагаж үүргэлсэн номхон морин дээр лимбэ үлээн буй хоньчинхүүгилэрхийлсэнбөгөөдтүүнийлимбэний аянд унасан морь нь уярч, бөөн цагаан үүлс нь бүжин наадах мэт хөдөлж байгаагаар зургийн гол


дүр, өгүүлэмжийг гаргасан нь зохиомж, өгүүлэмж, гүйцэтгэл, арга ажиллагаагаараа аргагүй л түүх болон үлдсэн бүтээл юм. Тус бүтээлийн талаар судлаач Ц.Эрдэнэцог “Хязгааргүй тал нутгийн чөлөөг гаргахдаа өндөр хүчдэлийн баганыг орон зайн гүнд алслагдан байгаа байдлаар зурсан нь тал нутгийн хязгааргүй чөлөөг харуулсан оновчтой шийдэл болжээ” (2009, х-78) гэж тэмдэглэсэн бол судлаач Л.Батчулуун “зураач С.Нацагдорж “Лимбэчин” бүтээлдээ тал нутгийн байгалийн уян налархай хэмнэл, айзам хөгийг олж чадаад, үүн дээрээ үндэслэн тэгш бус айзам хэмнэлээр зохиомжлон баатрынхаа хөдөлгөөн, тэмүүлэл, дүр төрхийг яруу сайхнаар илэрхийлсэн байна” (2008, Х-59) гэжээ.

Үнэхээр л хонь болон тал нутгийг шууд дүрслээгүй ч бүтээлийг харсан хэнд ч тал нутагт хонио хариулаад явж буй хоньчин хүү гэж тайлж уншигдаж байгаа нь хүн ба амьтдын дотоод сэтгэлзүй, хөдөлгөөний донж, амьдралын хэв маяг нь өөрөө шууд илэрхийлэгдэж байгаагаараа гайхалтай бүтээл болсон юм. Судлаач С.Батчулуун “Байгалийн уянга, эх нутаг, хүний сэтгэл хөдлөлийг хослуулж монгол зураачийн уран санаа, сэтгэлгээний үр дүн болсон зураачийн бүтээсэн бүтээл бүр нь тухайн үеийн монголын зураасан зургийн урлагийн ололт амжилтыг илтгэн харуулж байлаа” (2011, х.127) хэмээсэн байна.

Зураач С.Нацагдоржийн 1970-аад онд бүтээсэн эх орны бүтээн байгуулалтын эзэн болсон ажилчин анги, үйлдвэрийн сэдэвт бүтээлүүдээс томоохонд тооцогдох бүтээл нь “Налайхын уурхай”, “Хар алт” зэрэг цуврал хулдаасан бар зургийн бүтээлүүд бөгөөд тус цуврал бүтээлээрээ Монголын Үйлдвэрчний Эвлэлийн нэрэмжит шагналыг хүртэж байжээ.Тэрээр эх орны нүсэр их бүтээн байгуулалтын эзэн болсон хөдөлмөрчин ард түмний оюун санааны дотоод ертөнцөд нэвтрэх, уран сайхны сэтгэлгээний нөр их эрэл хайгуул хийсний үрээр урьд өмнө нь Монгол оронд байгаагүй үйлдвэрийн сүрлэг барилга, шугам адил дурайх төмөр зам, уур манан суунаглах аварга үйлдвэрийн дүр төрхийг илтгэсэн “Налайхын уурхай” (зураг-6) бүтээлээ туурвисан юм. Тус бүтээлд Налайхын уурхайг нээсэн домог болон харь гаднын шунахай нар эх орны маань баялгийг сувдаглан зөөж байснаас эхлээд түүхчилж байсан санаагаа боловсруулан их уурхайн сүр жавхааг уран дүрслэлээр цомнон үзүүлсэн төдийгүй өнөөгийн ажилчин хөдөлмөрчин сэхээтний бие, хэл, сэтгэл оюунаар хувирч хөгжсөн их үйлдвэрийг тод томруун тусган бүтээсэн билээ (Батчулуун, 2008, х-148).

Зураг 6

С.Нацагдорж “Налайхын уурхай” 1971 он.
Хулдаасан бар 46х70



Эх сурвалж: Батчулуун.Л. (2008), Зураач С.Нацагдоржийн туурвил зүй. Х-146

Ийнхүү нэрт зураач С.Нацагдорж багшийн үлгэр дуурайлал, хулдаасан барын арга барил нь манай тэнхимийн уран бүтээлч багш нарт хүчтэй нөлөөлж олон арван бүтээлийг өөр өөрийн арга барилаараа хийж Монголын дүрслэх урлагийн хөгжилд үнэтэй хувь нэмрийг оруулж ирсэн байдаг. Үүний нэг нь доцент, зураач багш С.Жамц байлаа.

Зураг 7

С.Жамц. “Айраг” 1972 он. Хулдаасан бар 30х27



Эх сурвалж: Энхтунгалаг.Ж. Их говийн зураач. 2008 он

Зураач С.Жамц нь говь нутагт төрж говийн амьдрал ахуйд өссөн учир хулдаасан бар зурагт говь нутгийн үзэсгэлэнт сайхан байгаль, дархан цаазат ан амьтан болон говь нутгийн малчин амьдрал ахуй, нутгийн өвөрмөц онцлогийг энгийн хүүрнэл байдлаар уран нарийн зураасыг ашиглан бүтээж ирснээрээ онцлог уран бүтээлч байсан юм. Тиймээс ч судлаач, доктор Г.Мэндээ “Монголчуудын олон зууны туршид хөгжүүлж ирсэн уламжлалт номын барыг шинэ зууны технологиор баяжуулан орчин үеийн дүрслэх урлагийн нэг чиглэл болгож, бие даалган хөгжүүлж чадсан гайхамшигт уран бүтээлч, зураач байсан нь түүний үнэлж баршгүй, мартаж боломгүй гавьяа билээ” (Энхтунгалаг, 2008, х.5) гэсэн бол судлаач, доктор С.Батчулуун “Зураач С.Жамцын уран бүтээлийн үнэ цэн нь хулдаасан бар зургийн хэллэгийн хамгийн эрхэм нандин зүйл болох хар, цагаан өнгийн ялгарал, зохицол хэмнэлийг олж хэрэглэдэг, байгалийн тогтоц, хүн болон амьтны хөдөлгөөн донжийг зөв олж чаддаг, байгаль, хүн, амьтны аяс араншин, төрх намбыг ургуулан бодож, урнаар сэтгэн үнэмшилтэйгээр амьдруулан дүрсэлж чаддагт оршиж байлаа” (Батчулуун.С, 2008, х.161) гэж бичсэн байгаа нь түүний хэрхэн чадварлаг уран бүтээлч болохыг харуулж байна.

Зураач С.Жамцын “Айраг”, “Говь нутгийн үзэсгэлэн”, “Хаврын өглөө”, “Салхитай өдөр” зэрэг бүтээлүүд нь социалист орнуудын хамтарсан үзэсгэлэнд дэлгэгдэж өндөр үнэлэгдэж тухайн үедээ хулдаасан бар зургийн голлох төлөөлөгчдийн тоонд зүй ёсоор орж байжээ. Түүний “Айраг” (Зураг-7) бүтээлд намрын дэлгэр цагт малчны гэрт сөн дүүрэн айргаа тавьж, хуураа татаж, хул дүүрэн айргаа шимэн суугаа айлчин гийчид хуурын эгшигэнд уяран байгаа тэр л агшинг харуулсан байдаг. Зураач зургийн дэвсгэр дээр хүмүүсийг дүүрэн багтааж хар дэвсгэр дээр цагаан зураасаар дүрсэлсэн бөгөөд хуланд мэлтэлзэх айраг болон сөндөө цэлийн цайрах айргануудыг хагас дугуй дүрсээр тодотгон гаргаж өгсөн нь хэн хүнд шууд тусаж зургийн агуулгыг бэлхнээ илтгэнэ.

Харин “Хаврын өглөө” (Зураг-8) бүтээлдээ хаврын дулаахан өглөө цасны цоорхойг даган хонио бэлчээж буй малчинг дүрсэлсэн бөгөөд ямар ч үүлгүй цэлмэг тэнгэрт цацран гэрэлтэх өглөөний нарны туяа нь хаврын дулаахан өглөөг өөрийн эрхгүй санагдуулна. Түүний наад талд дүнхийх уулсыг гэрлийн эсрэг бараан өнгөөр үлдээж түүний наад паланд алсад сунаих өндөр хүчдэлийн шонгуудыг хийсэн нь орчин үеийн соёлт нийгмийн их довтолгоон малчин ардын хотыг ч гэрэлтүүлэн гийгүүлж байгаа далд санааг

илтгэх мэт.

Зураг 8

С.Жамц “Хаврын өглөө” 1977 он. Хулдаасан бар, 55х80



Эх сурвалж: МУЗ Галерейн цомог. 2007 он. Х-49.

Өглөө хотноосоо хөдлөн цасны бараан хэсэгт гарсан өвс болон нарны илч, цасны усаар тэжээгдэн гарсан дөнгөж цухуйн байгаа шинэхэн ногоог уралдан идэх хонь, ямаануудын идэвхтэй шаргуу хөдөлгөөн, шөнөжин идээшилж амарсан хүлэг морины эрчтэй, хүчтэй, омголон хөдөлгөөн, түүнийг тогтоон байгаа малчны хөдөлгөөн зэрэг нь маш үнэмшилтэй, бас уран яруу өгүүлэмжтэй, бодит амьдралыг дүрслэн харуулсан бүтээл юм.

Зураач С.Жамцын говь нутгийн үзэмж, говийн дархан цаазат ан амьтдыг дүрслэн илэрхийлсэн “Хулангийн тойром”, “Хавтгайн сүрэг”, “Хулангийн сүрэг”, “Угалзын сүрэг”, “Янгирын сүрэг” гэх мэт бүтээлүүд (Зураг-9)-ийг нь гадаадын зочид төлөөлөгчид төдийгүй дотоодын үзэгч олон ихээхэн шохоорхож үнэлдэг байжээ.

Зураг 9

С.Жамц. Говийн дархан цаазат амьтадын бүтээлүүд. Цуврал хулдаасан бар зураг.



Эх сурвалж: Энхтунгалаг.Ж. Их говийн зураач. 2008 он

Учир нь говь нутгийг нэг бүхэл найрал хөгжим гэж үзвэл түүний өнгө эгшиг болсон төрөл бүрийн ан амьтан, дахин давтагдашгүй өөр өөр байгалийн өвөрмөц тогтцуудыг хоршуулбал хэзээ ч дуусахгүй олон янзын эгшиг аялгуу гарахтай адил дахин давтагдашгүй өнгө, дүрслэл, зохиомжтой бүтээлүүд дуусахгүй арвин төрөх биз ээ. Тиймдээ ч уран зураач С.Жамцыг “Их говийн дууч” хэмээн уран бүтээлчид, урлаг судлаачид, эрхэм олон шавь нар нь тодорхойлдог юм.

Түүний бүтээлд говийн тойром, бүрд, уул хад, элсэн цөл, хайрга чулуу зэргийг тухайн ан амьтадын онцлог, уран нарийн хөдөлгөөнүүдэд нь тохируулан маш өвөрмөц, дахин давтагдашгүй байдлаар зохиомжлон авч хийдгээрээ онцлогтой байдаг. Тухайлбал түүний “Янгирын сүрэг” (12х25) бүтээлд өндөр уул хаданд л байдаг гэх янгирын сүрэг говийн их талд ч давхиж байдаг гэдгийг дүрслэхдээ говийн бут, харгана зэргийг хамтатгаж илэрхийлсэн бол “Сартай шөнө” 1976 (18х26) бүтээлдээ говийн их тэргэл сартай шөнө ботгоо дагуулсан ингэ өдрийн их халуунд хэвтэж өнжөөд үдэш сэрүүн оронгуут захаараа хатаж хагарсан говийн бяцхан тойромд ирж цангаага тайлан зогсох агшинг үзүүлсэн байдаг. Ингэхдээ тойрмыг тал дугуй байдлаар авч, тэргэл сарны тусгалд буух дүрсийг тэнцвэртэй байдлаар зохиомжлон шийдсэн нь онцлог болсон байдаг.

Зураач, уран бүтээлчдийн дунд “Барын” Балдан гэж алдаршсан багш Б.Балдан зураачийн бар зургийн бүтээлүүд нь тухайн цаг үед мартагдаад байсан модон бар зургийг сэргээсэн том төлөөлөл хэмээн үнэлэгддэг. Б.Балдан зураачийн монголчуудын түүх, домог, туульсын сэдвээр зурсан бүтээлүүд нь одоо ч монголын хэвлэлийн болон суурь бар зургийн гол төлөөлөл болон тодорсоор байна.

Түүний “Төлчин” (Зураг-10) хэмээх хулдаасан бар зургийн бүтээлд хаврын нялх ногоонд дурлан дайрах морин дээр дөнгөж төрсөн нялх төл тэвэрсэн малчин бүсгүйн баясгалантай царай, эрт гарсан хурга ишиг нь хоорондоо наадан тоглож, хонь ямаа нь тааваар байх хаврын нэг аз жаргалтай өдрийг харуулсан байгаа нь өнгө зохиомж, өгүүлэмж зэргээрээ дахин давтагдашгүй болж чадсан байдаг.

Зураг 10

Б.Балдан “Төлчин” 1961 он. Хулдаасан бар



Эх сурвалж: МУЗГалерейн цомог. 2007 он. Х-38.

Зохиомжийн хувьд тэнгэр газрыг ойролцоо хэмжээнд хуваан авч хөвсийн байх цайвар үүлсийн наана морьтой малчин бүсгүйг тод томруун дүрслэн илэрхийлсэн нь гол дүрийг олон дүртэй харшуулахгүй шууд харагдуулж чадсан байна. Туслах түр болох хонь, ямаа, ишиг хургыг газрын хэсэг дээр бараан цайруугаар нь тоглуулан дүрсэлсэн нь утга нэмж үйл явдлыг тодруулж байгаа ч гол дүрд садаа болохгүй үйл явдлыг нэмэгдүүлж, зургийг улам баялаг болгож байгаагаараа дорвитой бүтээл болж чадсан байна. Энэхүү бүтээлийг тухайн үед залуучуудыг илгээлтээр хөдөө малчин болгох их аян өрнөж хөдөө нутгийн сайхан, малчин ахуй соёлыг түгээн сурталчлах их зорилгын хүрээнд хийсэн ухуулгын сэдэвт бүтээлүүд нэгэн гэж үзэх нэг нь байдаг бол судлаач Ц.Эрдэнэцог “Жирийн амьдралын байдал, монгол үндэсний хувцас, эд хэрэглэлийг судалж зурсан судалгааны бүтээл” (2007, х-6) гэж бичсэн байдаг. Түүний бүтээсэн “Эртний баатар”, “Хоёр малчин”, “Мөөг хэлхэж байгаа охин” зэрэг нэлээдгүй бүтээлүүд нь олонд танигдсан бөгөөд зураачийн уран бүтээлүүдийн аль ч хэсэгт дутуу дулимаг зүйлгүй, төгөлдөр боловсрогдсон байдгаараа онцлог юм.

Багш Ц.Ядамжавын Хөдөлмөрийн талбар дахь бүтээн байгуулалт, эгэл жирийн малчин ахуй амьдралыг харуулсан “Хадлан дээр”, “Төлчин”, “Эмээ зээ хүүтэйгээ” зэрэг хулдаасан барын бүтээлүүдийг дурьдаж болно.

Зураач “Хадлан дээр” (Зураг-11) бүтээлийнхээ санааг Батсүмбэрийн САА-д дадлагын оюутнууд удирдан ажиллаж байхдаа олж судалбар судалгаа

хийн бүтээсэн гэдэг. Тус бүтээлдээ намрын нарлаг өглөө оюутнууд майхнаасаа гаран өдрийн халуунд амны цангаа гаргах савтай цайгаа багаж хэрэгслийн хамт барин өөрсдийн хадаж овоолсон бухлан дундуур урам зоригтой бас хөөр баясалтай алхаж байгааг илэрхийлсэн байдаг. Тус бүтээлээрээ оюутан залууст хөдөлмөрийн сайн сайхан, тэр дундаа хамтын их хөдөлмөрөөр ямар их ажлыг амжуулж бас бүтээлж болдгийг цаад талын хэсэгт байх олон бухлуудаар төлөөлүүлэн илэрхийлж ойлгуулсан маш өвөрмөц бүтээл болсон юм.

Зураг 11

Ц.Ядамжав. “Хадлан дээр”. Хулдаасан бар 28х55



Эх сурвалж: Ядамжав.Ц. Уран бүтээлийн цомог.

Багш Ц.Ядамжавын “Эмээ зээ хүүтэйгээ” (Зураг-12) бүтээлд зээ хүү нь өөрийн зурсан зургаа эмээдээ үзүүлж эмээ нь түүнийг нь шимтэн үзэж урам хайрлаж байгааг дүрсэлсэн бөгөөд тус бүтээлдээ зураач өөрийнхөө ээжийг хүүтэйгээ хамт дүрсэлсэн бодит хөрөг зургийн бүтээл юм.

Зураг 12

Ц.Ядамжав. “Эмээ зээ хүүтэйгээ”. Хулдаасан бар 29х44



Эх сурвалж: Ядамжав.Ц. Уран бүтээлийн цомог.

Зургийн цаад хэсэгт өөрийнхөө гэрийн эвтэй дөрвөн амьтан буюу тумбааш, ваартай цэцэг, номын шүүтээ, хивс зэргийг бүтэн биш цухуйлгаж оруулсан нь зохиомжийн хувьд өвөрмөц болсон юм.

Зураач, багш Ц.Ядамжав 1971 онд Булган аймгийн Хишиг-Өндөр сумын харьяат Хөдөлмөрийн баатар, хоньчин Очирын гэрт очиж мал маллах арга ухаан, түүний ажил хөдөлмөрийн туршлагыг судлан өдрийн турш дагалдан явж судалбар судалгаа нэлээдгүй хийж, бас зан төлөвийг ажиглан байж “Хөдөлмөрийн баатар Очир” (Зураг-13) хөрөг зургийн бүтээлээ туурвисан хэмээн хүүрнэн дурсдаг. Тус бүтээл нь бодит хүнээс судалгаа хийсэн хөрөг зургийн бүтээл боловч түүний ажил мэргэжлийн онцлогийг бахдан харуулсан хонь ямаа, амьдран сууж байгаа нутаг орны байгаль, цаг уурыг хамтатган илэрхийлсэн аж байдал, үйл явдлыг харуулсан хулдаасан бар зургийн шилдэг бүтээлийн нэг юм.

Зураг 13

Ц.Ядамжав. (1971) “Хөдөлмөрийн баатар Очир”. Хулдаасан бар



Эх сурвалж: МУЗГалерейн фонд.

Зураач, багш Ж.Төмөрбатын “Уурхайд”, “Хөдөлмөрийн талбар дээр”, “Хот”, “Манай дайчид” зэрэг цэрэг эх орон болон ажил хөдөлмөрийн их талбар дээрх үйл явдлыг уран сайхны аргаар харуулсан цуврал бар зургууд нь Монголын уран зургийн галерейн сан хөмрөгт хадгалагдаж байдаг билээ.

Зураач, багш Ж.Төмөрбатын хулдаасан бар зургийн бүтээлүүд нь социализмын материал техникийн баазыг байгуулж байсан тэр цаг үед энх цагийн хөдөлмөрийн талбарт мөр зэрэгцэн ажиллаж байгаа Монгол-Зөвлөлтийн ахан дүүс, даян дэлхийн энх тайвны төлөө гэсэн сэдвүүдэд бүтээгдэж байлаа. “Манай дайчид” 1981 (зураг-14) цуврал бүтээлдээ монгол-зөвлөлтийн энх цагийн цэрэг армийн дайчид эх орныхоо бүтээн

байгуулалтад гар бие оролцож орчин цагийн шинэ хотыг бий болгоход хэрхэн хөдөлмөрлөн зүтгэж ирсэн түүхэн үйл явдлыг харуулахын зэрэгцээ цэрэг армийн болон барилгын зохион байгуулалттай нөр их хөдөлмөр, машин техник зэрэг нүсэр том сүрлэг техник хэрэгслийг өвөрмөц байдлаар зохиомжлон өрнүүн их бүтээн байгуулалт, зогсошгүй их хөдөлмөр, зүтгэл, эх орны энхийн манаанд зогсож байгаа эр цэргүүдийн бахдам үйлийг харуулж чадсан түүхийн гэрч болох бүтээл юм.

Зураг 14

Ж.Төмөрбат “Манай дайчид бүтээн байгуулалт дээр” 1981 он. Цуврал хулдаасан бар зураг.



“Манай дайчид-Батлан хамгаалах бэлтгэл сургуулилт дээр”



“Манай дайчид-Бүтээн байгуулалт дээр”



“Манай дайчид-Эх орон минь амгалан байг”



“Манай дайчид-Соргог манаа”

Эх сурвалж: МУЗГалерейн фонд

Түүний “Хот” 1990 (Зураг-15) хэмээх бүтээлд зургийн зүүн дээд хэсэгт байх залуучуудын нөр их хөдөлмөр зүтгэлийн үр дүнд энэ их хот бий болж ахмад үе, хүүхэд багачууд бүгд сэтгэл өөдрөг аз жаргалтай амьдрах боломж бүрддэг гэсэн санааг өвөрмөц өгүүлэмжтэй, зохиомжийн өвөрмөц шийдлээр илэрхийлэн үзүүлсэн байна.

Харахад энгийн өгүүлэмжтэй бар зураг мэт боловч гурвалжин, дөрвөлжин дүрсүүдийн тоглолт, огтлолцол, тэдгээрийн хүнд хөнгөн харьцааг тааруулахын зэрэгцээ барилгын кран, байшингийн бэлдэц зэргийг зориуд таллан оруулж, зарим хэсэгт барилгын хээ чимэглэл зэргийг зохиомжийн нэг хэсэг болгон толбо дүрс байдлаар авцалдуулан хийсэн нь нэлээд шинэлэг, орчин үеийн дүрслэлтэй бүтээл болсон байдаг. Энэ нь хулдаасан бар зургийн уламжлалт хэв маяг сэтгэлгээг эвдсэн шинэ бүтээл болж чадсан юм.

Зураг 15

Ж.Төмөрбат “Хот” 1990 он. Хулдаасан бар 75х57



Эх сурвалж: Монголын зураачид. МУЭ-ийн цомог. 2017 он. Х-314.

Уран бүтээлч, багш Т.Батчулууны эртний туульсын сэдэв дээр тулгуурласан хэд хэдэн өвөрмөц сонин бар зургийн бүтээлүүд болоод уурхайчин, барилгачин зэрэг нийгмийн бүтээн байгуулалтад оролцож байгаа хөдөлмөрчдийн ажил мэргэжлийг сурталчилсан, тэдгээрийн их хөдөлмөр зүтгэлийг алдаршуулсан бүтээлүүд цөөнгүй хийгдсэн байдаг.

Т.Батчулуун багш Хөвсгөл нутгийн уугуул хүн учир Хөвсгөл нутгийн байгаль, ан амьтанг төдийгүй нутгийн зон олны амьдралын өвөрмөц хэв шинжийг уран бүтээлүүддээ түлхүү тусган үзүүлдэг байлаа.

Түүний “Барилгачид” (Зураг 16) бүтээлд Хөвсгөл нутгийн өндөр уулс, ой хөвчтэй байгалийн үзэсгэлэн бүрдсэн газар нутгийн залуучууд дүнзэн байшин барьж байгаа агшинг үзүүлсэн байдаг. Зураач тус бүтээлдээ зургийн хамгийн цаад хэсэгт байгаа олон уулсыг хийхдээ хамгийн цаад талын уулыг өргөн цагаан зураасаар, дунд хэсэгт байгааг нь дунд зэргийн цагаан зураасаар, хамгийн наана байгаа уулсыг нарийн цагаан зураасаар ялгаж хийсэн нь зураасны хооронд харагдах бараанаар

уулсын орон зайг илэрхийлж болохыг маш нарийн мэдэрч хийсэн байдаг. Бар зургийн бүтээлүүдэд олон уулсын ингэж ялгаж хийж үзүүлсэн нь тун ховор байдаг.

Зураг 16

Т.Батчулуун “Барилгачид” Хулдаасан бар 30х30



Эх сурвалж: МУБИС-Дүрслэх урлагийн тэнхимийн фонд.

Харин уулсын наана дүнхийн байгаа хөвчийн их ой, түүний наад хэсэгт барьсан байшингуудыг бараанаар шийдэж уулсаас ялгамжтай болгож өгсөн ч уулсдаа нэгдэж цул болж харагддаг. Зургийн наад хэсэгт залуус дүнз бэлтгэж зарим нь өрж байгаа харагдах бөгөөд тэдгээрийг цагаан дээр хар, хар дээр цагаан байхаар тооцоолж хийсэн байдаг. Мөн түүний Хөвсгөл нутгийн онцлогийг илтгэсэн бүтээл бол “Цагаан нуурын загасчид” (Зураг-17) хулдаасан бар зургийг нэрлэж болно.

Зураг 17

Т.Батчулуун “Цагаан нуурын загасчид” Хулдаасан бар



Эх сурвалж: МУБИС-Дүрслэх урлагийн тэнхимийн фонд.

Тэрээр тус бүтээлдээ өөрийн төрсөн нутаг Рэнчинлхүмбэ сумын нутагт орших Цагаан загасны эх орон гэгддэг Дээд цагаан, Заяат нуурын эргээр амьдарч загас агнаж өөрсдийн амьдрал ахуйгаа залгадаг нутгийн зон олныг харуулахыг зорьсон бөгөөд зургийн наад хэсэгт сүрлэг том загас сэрээдэн гаргаж ирсэн хоёр загасчин барьсан ангаа гайхан бахдаж байгаа дүр төрх ажиглагддаг бол түүний цаана загасны урт торыг дамнуулан үүрсэн загасчид далайд тороо тавихаар эрэг даган алхаж байгаа харагдана. Далайн ус бараантан дүнхийж нарны гялбаа далайн мандалд ойн гялбах нь сүртэй харагдах бөгөөд тэрхэн чөлөөнд завьтай загасчид өөрсдийн тороо чирч аажмаар сэлүүрдэнэ. Далайн эргээр загасчдын модон байшин эл хульхан харагдах нь түүнд амьдардаг хүмүүс нь далайдаа загасчлаад завгүй байгааг илтгэнэ. Цагаан нуурыг тойроод зөвхөн загасчид гэлтгүй цаатан зэрэг олон ястнууд амьдарч нуурын хишиг буянаар амьдрал ахуйгаа залгуулж байдаг гэдгийг цаатай хоёр хүнээр төлөөлүүлэн харуулсан байна.

Т.Батчулуун багшийн уул ус, нуур далайг харуулсан эдгээр олон олон сайхан бүтээлүүд нь Болгар, Орос, Энэтхэг зэрэг олон орны уран бүтээлчдийн үзэсгэлэнд дэлгэгдэж үзэгч олноос өндөр үнэлэлт авч байсан бөгөөд ОХУ-ын Шушинскийн галерейд хулдаасан барын таван бүтээл нь хадгалагдаж байдаг. (Дашхүү, 2013, х-166).

Зураасан зургийн багш Л.Эрдэнэбатын хулдаасан бар зургийн аргаар хийсэн “Мөнх дурсагдах ялалтын дууль” (Зураг-18) цуврал зураг нь дайны хар сүүдэр, аюул, ард иргэдийн зовлон зүдгүүр, түүнийг амь биеэ үл хайхран халуун амь бүлээн цусаа урсган байж эх орондоо агуу их ялалтыг авч ирсэн үнэ цэнэ, түүнийг хэзээ ч үл мартаж болох гашуун сургамж, үе үеийн үр хойч нь энэ их үнээр олсон ялалтыг мөнхөд дурсан санаж эх орноо улам ихээр хайрлахыг сануулсан гайхамшигтай бүтээл юм. Хэдийгээр тус тусдаа таван өөр зохиомжтой, таван өөр үйл явдалтай, таван өөр зураг боловч нийлээд нэг бүхэл болж нэгэн том үйл явдлын дарааллыг харуулсан нэг зураг болж нэгдэж харагдахаар шийдсэн нь бусад уран бүтээлчдийн бүтээлүүдээс илүү онцлогтой болсон юм.

Зураг 18

Эрдэнэбат.Л. “Мөнх дурсагдах ялалтын дууль”
Цуврал хулдаасан бар.



Эх сурвалж: МУЗГалерейн фонд

Ийнхүү зургийн тэнхимийн багш нар нийгмийн бодлогод тулгуурласан захиалгат сэдвээс гадна эгэл жирийн амьдралын байдал, эртний үүх түүх, үндэсний онцлогоос сэдэвлэсэн аж байдлын бүтээлүүд хийхийн зэрэгцээ эртний хадны зураг, хүрлийн үеийн дүрслэл, үлгэр домгийн сэдэвтэй утга донжид бүтээлүүдийг ч хийж эхэлсэн байдаг.


Зураач С.Батчулуун багшийн эртний хадны зурган дахь дүрсийг зохиомжийн өвөрмөц бэлгэдэл дүрстэй холбон зохиомжилсон хулдаасан бар зургийн бүтээлүүд нь өнөө цагт монголын бар зургийн хөгжлийн шинэлэг арга хэлбэрийг харуулсан тод жишээ болдог. Учир нь С.Батчулуун багш хадны зураг дүрслэлийн уран сэтгэмж, түүний уран сайхны хийсвэрлэлийн талаар нэлээдгүй судалгааг хийсэн судлаач учир түүний бүтээлүүдэд нь эдгээр утга бэлгэдэл, ёгт санаа, дүр дүрслэл нэвт шингэсэн байдаг.

Зураачийн “Монгол натюрморт” (Зураг-19) хэмээх цуврал бар зургийн бүтээлүүдэд монгол зургийн урвуу алслалт, олон цэгийн алслалт зэргийг ашигласан дүрслэлүүд байх бөгөөд тэдгээрийг хадны дүрс зураг, хүрлийн үеийн ховор сонин эдлэл юмсын дүрслэл, уламжлалт монгол ахуй соёл, эд өлгийн зүйлстэй хослуулан илэрхийлсэн нь өвөрмөц бөгөөд зохиомжийн шийдлийн хувьд ч дахин давтагдашгүй байдлаар харуулснаараа онцлог юм. Мөн тус бүтээлүүддээ зарим хэсгийг цул бараан тоноор орхиж түүн дээр нь нарийн цагаан зурааснуудаар шаардлагатай

хэдхэн зүйлсийг товчхон тэмдэглэж, зарим хэсэгт нь нэлээд нарийн ажиллагаатай дүрслэл, үйл явдлыг тод цагаан зураас, дүрс, толбоор илэрхийлсэн учир бүтээлүүд нь хэт их эрээн, эсвэл хэт их дүлий бололгүй, зохиомжийн хувьд тэнцвэр, хүнд хөнгөний харьцаа, өгүүлэмжийг илүү тооцож хийсэн учир бүтээлийнхээ санааг шууд өгч чадахуйц онцлогтой бүтээлүүд болсон байдаг.

Зураг 19

С.Батчулуун “Монгол натюрморт” 1995 он.
Цуврал хулдаасан бар.



Эх сурвалж: Батчулуун.С. Нүүдэлчдийн соёл, урлагийн жимээр мөшгөхүй. 2011 он. X-190

Зураачийн “Байгаль” (зураг-20) хэмээх бүтээлд энэхүү хадны өвөрмөц сонин дүрслэл, ёгт санаа, хүн байгалийн уялдаа холбоог харуулсан байдаг. Эдгээр нь хүн байгалийн нэг хэсэг байсан, одоо ч байгаа, байсаар ч байх болно гэдгийг балар эртний хүмүүсийн хадны зураг дүрслэл, дунд үеийн гэр орон, малчин ахуй амьдрал, орчин цагийн байшин, техник хэрэгсэл зэргийг хамтатган дүрсэлсэн бөгөөд энэ бүх цаг үед байгалиасаа хоол тэжээл үр жимсээ хүртэж ирсэн төдийгүй байгалийн хүчин дор амьдардаг гэдэг санааг савтай жимс харуулах мэт санагдана.

Мөн нөгөө талаас нь харвал жимстэй натюрморт юм шиг хэр нь чөлөөт задгай зохиомжийг ашигласан нь үзэгчдийн анхаарлыг тавьдаг юм.

Зураг 20

С.Батчулуун “Байгаль” 1992 он. Хулдаасан бар 35х50



Эх сурвалж: Батчулуун.С. Нүүдэлчдийн соёл, урлагийн жимээр мөшгөхүй. 2011 он. X-192

Зураач багш С.Батчулууны “Говийн малчныд” (Зураг-21) бүтээлд Говийн малчин айлд УАЗ машинтай гийчид ирж ахмад настныд нь эхлэн бууж алс холын мэдээ дуулган хүүрнэн байгааг харуулсан байдаг. Тус бүтээлийг хараад хүн бүр өөр өөрийн харах өнцөг, үзэл бодол, сэтгэгдлийг олж хардгаараа сонирхолтой. Учир нь тус бүтээлийг дэлгэмэл монгол зургийн аргаар гэр дотор болж байгаа үйл явдлыг тодорхой харуулсан бөгөөд түүний хамт гадаа байгаа машин тэрэг, мал ахуйг хослуулан өгүүлэмж хүүрнэлтэйгээр хамтатган үзүүлсэнд оршино.

Зураг 21

С.Батчулуун “Говийн малчныд” 1990 он.
Хулдаасан бар.



Эх сурвалж: Батчулуун.С. Уран бүтээлийн цомог. 2002 он.

Энэхүү бүтээлд ээж аавынхаа гэрийн дэргэд дөнгөж саяхан шинэ гэр барьж айл болсон залуу хосын амьдралыг дүрсэлсэн бөгөөд шинэхэн авдар, сав, зургийн жааз, орны хөшиг, эмх цэгцтэй хогшил хэрэглэлүүд харагдах бөгөөд бяцхан хүү нь үйл урлан байгаа ээжийнхээ дэргэд тоглож байна. Харин их гэрт нь нэгдлийн дарга, эмч, жолооч гурав цай ууж алс холын мэдээ дуулган гэрийн эзэнтэй хүүрнэн байгаа харагдана. Гэрийн гадна саяхан ирсэн машины бинзен тосны үнэрийг жийрхэн, ойр хараагүй тэр л содон зүйлийг хол зайнаас ажиг гайхаж байгаа хонь ямаа зэргийг бодитой, үнэмшилтэй дүрслэхдээ бараан дэвсгэр дээр цагаан зураасаар ялгаруулан илэрхийлсэн байна. Зохиомжийн хувьд хоёр гэрийн доторх онцлог ялгаа, болж байгаа үйл явдлыг тод томруун гаргах үүднээс нарийн зурааслалаар нягт ажиллаж харин гэрийн хүрээг өргөн цагаан зураасаар зааглан нэгтгэж өгсөн нь бараан дэвсгэр дээрээс маш ялгамжтай болсон бөгөөд хоёр гэрийн олон нарийн зурааслал ч мөн бие биедээ садаа болохгүй тус тусдаа уншигдаж байна. Мөн эргэн тойронд нь саад болох сул дүрслэл оруулалгүй бараанаар нь үлдээж нэлээд зааг ялгаатай хийсэн нь оновчтой шийдэл болсон бөгөөд харин машин болоод хонь, ямаа, тэмээ зэргийг гэрээс нэлээд зайтай хэр нь дэвсгэртийн сул зайг зөв ашиглан машинтай дасан зохицож амжаагүй гайхан байгаа хонь ямааны авир занг харагдуулах үүднээс машиныг сондгой байлгаж дүрсэлсэн нь зургийг илүү өгүүлэмжтэй харагдуулж чадсан байдаг.

Ийм л мундаг амжилтуудыг бидний ахмад үеийнхэн XX зууны монголын дүрслэх урлагт тэр дундаа зураасан зургийн төрөлд үлдээсэн байдаг бөгөөд судлаач С.Батчулууны “Хэсэг хугацаанд Дүрслэх урлагийн тэнхимд хулдаасан бар зургийн урлаг төвлөрөх чиг хандлагатай байсан нь манай ахмад үеийн зураачдын арвин баялаг өв уламжлал, уран зургийн ангийн багш, оюутнуудын бүтээлч сэтгэлгээ ихээр нөлөөлж байсныг үгүйсгэх аргагүй юм” (2011, х-166) гэсэнтэй санал нэг байна. Учир нь манай ахмад үеийн багш нар нь зөвхөн уран бүтээлчдийн багш байгаад зогсохгүй бие биедээ нөлөөлөл ихтэй, харилцан зааж бас суралцаж ирсэн гайхамшигтай туршлагатай байсны үр дүн юм.

Дүгнэлт

Манай ахмад үеийн уран бүтээлчдийн нэг онцлог нь эрэл хайгуул судалгааг сайн хийдэг, монгол орныхоо өнцөг булан бүрд очиж амьдрал ахуй, үндэстэн ястны өвөрмөц онцлог, ёс заншил, хэв маягийг маш сайн судалж тэр чинээгээр үнэн

бодитой тод томруун бүтээлүүдийг бүтээдэг байсан нь тэдгээрийн туурвисан бүтээлүүдээс нь тодорхой харагддаг юм.

Эцэст нь тэмдэглэхэд зураасан зураг хэмээгчийг тэр болгон аваад зураач болгон түүнийг хийгээд байдаггүй өвөрмөц чухал төрөл учир түгээмэл хөгждөггүй онцлогтой урлаг бөгөөд зургийн тэнхимийн үе үеийн уран бүтээлч багш нар эрт үеийн зургийн уламжлалт онцлогийг өвлөн авч тодорхой цаг үе бүртээ шинэ үеийн хулдаасан бар зургийн төрлийг хослуулан Монголын орчин үеийн зураасан зургийг хөгжүүлж бас өвлүүлж ирсэн бөгөөд судлаач Б.Бадрахын “Зураасан зураг нь гэрэл сүүдрийн нарийн харьцаа, хар цагаан өнгийн шүтэлцээ холбооны үндсэн дээр илэрхийллээ товч тодорхой, хурц тод гаргагдаараа өнгөт зургаас давуутай байдаг ч илэрхийллийн үндсэн арга нь цэг, толбо, шугам зураас юм” (2000, х-87) гэж цохон тэмдэглэсэнтэй адил цэг, толбо, зураасыг шүншиглэн амилуулсан түүхэн гавьяатай юм.

Дээр дурдсан зураач багш нарын маань бүтээлийн сэдвүүд нь цаг үе нийгмийн шаардлагаар захиалгатай хийгддэг байсан ч өөрсдийн төрөлх нутаг, бага залуугаасаа өсөж төрсөн уул ус, ургамал амьтан, газар шороо нутаг, ус, ахуй байдлаа дүрслэх нь илүүтэй байсан нь харагдаж байна. Мөн өөрсдийн хийдэг бас чаддаг зүйлсийг бусдадаа харамгүй зааж хүртээж байх нь зөвхөн хэсэг бүлэг хүмүүсийн эрх ашиг бус цаашлаад нэг салбарын хөгжил цэцэглэлтэд төдийгүй эх орныхоо баялагт үнэтэй хувь нэмэр оруулж болдгийг харуулсан нэг том жишээ бол манай үе үеийн багш нарын хулдаасан бар зургийн бүтээлүүд харуулж байна.

Өнөөдөр манай тэнхимийн уран бүтээлчдээс зураач, профессор Ц.Эрдэнэцогийн таталбар, нүдэ буюу биеийн гоо сайхныг илэрхийлсэн настель болон холимог техникийн аргаар хийсэн “Нюдэ” цуврал ажлууд, зураач М.Уранбэрх, Д.Булгантуяа нарын судалбар бүтээлүүд, зураач С.Батцоожийн эртний хадны зураг, хүрлийн дурсгалууд дахь бэлгэдэлт дүрслэлийг сэтгэлгээний хэв шинжид оруулан зохиомжилсон “Таван эрдэнэ”, “Нутгийн зүг”, “Морьд”, “Хэл, хил, мал гуравтайгаа байвал хэн баян бэ? Монгол баян” зэрэг цуврал зураасан зургууд нь өнөөдрийн зураасан зургийн ертөнцөд өөрийн бүтээлийн өнгө аяс хэллэгээрээ танигдсан төдийгүй мэргэжил нэгт нөхөд, урлаг судлаачдад үнэлэгдэж анхаарлыг нь татаж буйд бид бүхэн сэтгэл хангалуун байдаг билээ.

Тиймээс манай тэнхимийн багш нар бид багш төдийгүй уран бүтээлчид, уран бүтээлчид

төдийгүй судлаачид учраас монголын дүрслэх урлагт бүтээл туурвилаараа танигдсан үе үеийн гайхамшигт багш нарынхаа эрдмийн их бамбарыг бадраан, уран бүтээлч уламжлалыг түүчээлэн хөгжүүлсээр байна. Уран бүтээлч багш нарын уран бүтээлээс оюун сэтгэлгээ нь хэдий чинээ шинэлэг бөгөөд чадварлаг байх бүрийд шавь нарын уран сэтгэмж, мэдрэмж, авьяас чадвар нь төдий чинээ хөгжих учир багш бүр яруу сайхны хязгааргүй орон зайд ямагт шинийг эрэлхийлсээр байх болтугай.

Ашигласан материал

- Бадрах, Б. (2000). Монголын зураасан зургийн судалгааны зарим асуудал. Монголын соёл урлаг судлал. Боть 3-4. х.87, 92
- Батчулуун, Л. (2008). Зураач С.Нацагдоржийн туурвил зүй. Улаанбаатар: Мөнхийн үсэг.
- Батчулуун, С. (2011). Нүүдэлчдийн урлаг, соёлын замаар мөшгөхүй. х.127. Улаанбаатар.
- Батчулуун, С. (2002). Уран бүтээлийн цомог. Улаанбаатар.
- Дашхүү, Д. (2013). Улаан тайгын хүү. Дурсамж өгүүлэл, ДУТС-55 жилд.
- Дүрслэх урлагийн тэнхим. (2009). Дүрслэх урлаг судлал-1. Улаанбаатар: Алтан хэвлэл
- Саруулбуян, Ж. (2008). Эрчимт увидаслаг туурвилын тухай. Их говийн зураач. Улаанбаатар: ОБ пресс
- Содномцэрэн, Л. (1976). Зураасан зураг. Орчин үеийн монголын дүрслэх урлаг. х.57. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар
- Цэвэл, Я. (2013). Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар
- Энхтунгалаг, Ж. (2008). Их говийн зураач. С.Жамцын намтар уран бүтээлийн эмхэтгэл. УБ: ОБ пресс
- Эрдэнэцог, Ц., Энхцэцэг, Д. (2007). Монголын зураасан зураг. МУЗГалерейн цомог. Улаанбаатар
- Эрдэнэцог, Ц. (2009). Монголын зураасан зураг. Дүрслэх урлаг судлал-1.

A live animator for dots, spots and lines

S.Battsooj

*Mongolian National University of Education,
School of Fine Art and Technology, Fine Art Department*

Abstract

The paper intends to discuss about the historical stages of how linoleum block prints have been developed in Mongolia. At the beginning of XX century, the Buddhist sutras and books used to be printed in woodblock. In the 1940s, since the western art styles and techniques were introduced to Mongolia for the first time, the need of subscription products such as book décor ideas, pictorial posters, and leaflets have been increased in the society. Due to this need, block arts have been rapidly developed in Mongolia, for instance, the different forms of block arts, such as woodblock, block of iron, stone block, and linoleum block prints have widely spread out in Mongolia. However, the use of Mongolian woodblock has been forgotten, so many art works on 'linoleum block prints' were commonly developed and have been created. They have easily become recognized among commoners in Mongolia. During this period that was 1960-1980s, the instructors and artists at the Department of Fine Arts of School of Fine Arts and Technology have paid special attention to the development of 'linoleum block prints' and made them more popular in Mongolia.

Key words

Print, Drawing, point, line, spot